



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/477

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Доройтсон бэлчээрийн газрыг нөхөн сэргээх, ойн зурвасын усалгааны зориулалтаар шинээр худаг гаргах (Баяннуур, Рашаант, Дашинчилэн, Гурванбулаг, Могод, Сайхан, Баян-Агт, Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Орхон сум)” ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Баясах ус эрдэнэ” ХХК-тай 235 942 919 (хоёр зуун гучин таван сая есөн зуун дөчин хоёр мянга есөн зуун арван ес) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т үүрэг болгосугай.

3. Тус хөрөнгийг холбогдох сумдын данс бүртгэлд тусгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга)-д, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.


4. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Баясах ус эрдэнэ” ХХК-ийн захирал (Б.Батбаяр)-д даалгасугай.

5. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

6. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010613

07 дугаар сарын 01-ний өдрийн 497 дугаар
Аймгийн Засаг даргын 2011 оны
захирамжийн хавсралт

| № | Нөхцөл шаардлага | Мөнгөн дүн | Хариуцах албан тушаалтан |
|---|-------------------------------------|--|--------------------------|
| 1 | Захиалагчийн техник хяналтын зардал | 4,145,830 | Ч.Амгалан |
| 2 | Нормчлолын сан | 41,514 | Ч.Амгалан |
| 3 | Магадлашгүй ажил | 3,734,897 | Ч.Амгалан |
| 4 | Алданги | Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.05 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна. | Д.Батцогт |
| 5 | Чанарын баталгаа | Гэрээний үнийн дүнгийн 5 хувь | Д.Батцогт Ч.Амгалан |
| 6 | Ажил гүйцэтгэх хугацаа | Хуанлийн 178 хоног | Ч.Амгалан |